



Орхон аймаг дахь цагдаагийн газрын эдийн засгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч Д.Гантөмөр

ХҮМҮҮН ЗАЯАНЫ ҮНЭ ЦЭНИЙГ ӨЛМИЙДӨӨ ГИШГЭСЭН АВЛИГА

Авлигал нь нийгмийн баялгийг тарамдуулан, төр засгийн чадварыг мөхөөж, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийг хаадгаараа ядуу иргэдэд хамгийн хүнд тусдаг"

НҮБ-ын ЕНБ-ийн дарга асан Кофи Аннан

Өт хорхойгүй модод үзэсгэлэн төгс найгаж, тэнд өт хорхойн хэрэг үгүйн адил, хүний мөр хүрээгүй газарт байгалийн үзэсгэлэн цогцолсон эх дэлхийдээ хүмүүн бид огт хэрэггүйг илтгэх буюу. Хүмүүн-сүйрэл үгүйсэн бол дэлхий минь ямархан байх хийгээд АВЛИГАЛ гээч огт үгүй бол амьдрал мөн тийм байхсан. Сэтгэлээсээ илүү үнэтэй хүн, хүнээс үнэтэй эрдэнэ гэж хаана байх билээ.

Авлигал гэж юу юм бол...? гэдэг асуултыг иргэншсэн хүмүүс өөрсдөөсөө хэтэрхий хожуу асуусан. Өөрсдийн бүтээсэн хиймэл оюун ухаандаа дарлагдан тамирдсан хойноо, УХААН нь өтөлж доройтсон үедээ л сая АВЛИГА хэмээх нууцхан чөтгөрийг өөрсдөөсөө илрүүлж, тэгээд маш үнэмшилгүйгээр үзэн ядаж, идэвхигүйгээр тэмцэж эхэлсэн ч, хамгийн инээдтэй нь амин сүнстэйгээ нөхцчихөөд байгаа энэ "чөтгөр"-ийг авлах эрлээ өөрөөсөө бус өрөөлөөс хайн бужигнасны алдсаар авлигын чөтгөр хүчээ авч амьдралын хаан суудлыг булаан эзэлсэн байна.

Авлигын талаар Эрдэмтэн Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь бичиг"-т Авлига гэдэг нь ёсон бусаар шунаж авсан эд гэж тайлбарлан тодорхойлсон байна. Харин эрдэмтэн Т.Намжим "Авлига гэдэг нь ёсон бусаар өгч авалцаж байгаа мөнгө төгрөг, эд зүйл юм. Авлигал гэдэг нь тэрхүү өгч авалцаж буй үйлдлийг илэрхийлж буй гаж үзэгдлийн нэр" гэжээ.

Монгол улсын хуулинд "авлига" гэдэг нэр томъёогоор бичиж тодорхойлсон байдаг. Монгол улс нь Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг 1996 онд баталж, 2006 оны 7-р сарын 6-наас энэхүү хуулийг шинэчлэн боловсруулж, 2006 оны 11-р сарын 1-нээс дагаж мөрдөхөөр 6 бүлэг 35 зүйлтэйгээр шинэчлэн баталсан. 2003 онд НҮБ-аас авлигын эсрэг конвенцийг батлан гаргасан. Монгол улс Авлигатай тэмцэх газрыг үүсгэн байгуулж 2007 оны 1-р сарын 11-нээс үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Авлигын гэмт хэрэг нь гэрчгүй, нууц далд аргаар, зохион байгуулалтын өндөр түвшинд үйлдэгддэг болохоор илрүүлэхэд төвөгтэй нь мэдээж. Авлига өгөгчийг бус авагчийг шийтгэдэг, мэдээлэгчийг урамшуулдаг хуультай болох хэрэгтэй. Хэрэв авлига өгсөн хүн, авсан этгээдийг гэрчлэн мэдээлээд байвал авах сонирхолтой хүн үгүй болж, энэ гэмт хэргийн хүрээ багасах учиртай. Харин хүчээр авлига өгөх гэж оролдсон этгээдийг мэдээлвэл урамшуулдаг болчихвол өгөх сонирхолтой хүний тоо ч цөөрөх биз. Авлигатай тэмцэхэд таны **ҮГҮЙ** гэсэн хариулт маш чухал үүрэг гүйцэтгэхийг хэзээ ч мартаж болохгүй! Таныг авлига авахгүй гэхэд хэн нэгэн буу тулгаж байгаад өгөхгүй нь лав.

Оюун ухааны маань шим шүлт хүч чадал хордож, хүн чанарын минь мөс хайлж, сэтгэл зүрх минь "үнэр орсон" хойно л...? сая л...? Нил мөрний Сац суврагаас Фараоны занданшуулсан шарилыг олоод "...Египетийн хаан сая үхчихлээ" гэж хашгиралдах мэт АВЛИГА -ын тухай бид шуугилдаж эхэллээ.

Тэгээд... Ура хашгиралдан босоод АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА тэмцэх гэсэн чинь...? Төр нь шүүх цагдаагаа бариад, шүүх цагдаа нь авлигыг барьсан ч авлига нь эргээд төрөө

барьчихаад, дэлхийн талыг эзэлж явсан домогт хаадын минь үлдээсэн төр өнөөдөр хөөрхий болжээ.

Тийм ээ. Төрийн хяналтгүй авлига луйварчдын тархин дотор хорт өвс мэт ургаж, авлигын алган дээр нүцгэн төр чичирч хэвтэхэд бид гадуур ундааны шил, Сола-ны лааз хайх мэт "тэр муу авлига"-ыг хайж, хаа нэгтэйгээс олдохоор нь тэмцэл хийж ялаад АВЛИГАГҮЙ НИЙГЭМ байгуулах гэж явнам. Төрийн халаас, түшмэдийн хормойд нуугдсан тэр АЗТАЙ АВЛИГА-тай бид яаж тэмцэж, харагдахгүй байгаа "дайсны цэрэг"-ийг хаана нь буудаж нам унагаах болж байна. Байгаа нь мэдэгддэгч харагддаггүй, өгсөн авсан нь ажлаа бүтээсэн, ашгаа олчихсон байгаа тэрхүү "таатай нууцад" нь хэрхэн нэвтрэх вэ?... Том дарга том иднэ, бага дарга бага иднэ гэлцдэг нь Сүхбаатарын талбайд шинэ жилийн шөнө нартай бороонд шавшуулна гэдэг шиг тэнэг үг биш шүү... Хүн нэмэгдвэл хүнс нэмэгддэг, дарга нэмэгдвэл авлига нэмэгддэг цаг үе шүү! Хүмүүн төрөлхтний язгуур ухаарал хэдийн үхсэн бол найдвар алга, унтсан бол сэрээх л хэрэгтэй. Авах идэхийн чөтгөр зөв ухаарлыг минь унтуулчихсанаас бус авлигын угаарт хордоод амьдрал үхжээ гэж бодогдохгүй байна. Эхийгээ идэж дуусаад найман хөлдөө тэнцэж босдог хилэнцэт аалз мэт Монгол улсаа идэн хоослож буй үй олон хилэнцэт хүн-хорхойнууд байгаа цагт Монгол улс мөхөх аюулд хүрэх нь үнэн бөгөөд хүмүүний сэтгэл эгнэгт ариусан гэгээрч, Төр нь цэвэр тунгалаг байж, Авлигагүй нийгмийг сонгон түүнийгээ цогцлоон бүтээсэн тохиолдолд л Монгол улс аврагдан хөгжлийн шинэ шатанд гарч ард түмэн нь амар тайван амьдрах болно. Манай **Цагдаагийн байгууллага** Төрийн байгууллагуудыг авлигагүйгээр манлайлсан анхны үлгэр жишээ байгууллага болно гэдэгт эргэлзэхгүйгээр найдаж, бас болоорой гэж ерөөмөөр байна.

Хүмүүний нийгэм гэгээрч хүн зоны сэтгэл угаагдахыг хүлээсэн мянган жилийг амьдрал өөрөө тэсч гарах (эсвэл бүх хүн яг зэрэг сэтгэлээ ариусган өөрийгөө ялах) тохиолдолд АВЛИГА УСТАНА.

Төрийн албаны бохирдсон ёс зүйг цэвэршүүлэх арга нь ажиллагсдын цалинг нэмж, гадны нөлөөнд автахааргүй болгох явдал гэв үү? Нэмэгдсэн цалиндаа ханаад цадчихдаг, тэгээд илүү харахаа больчихдог хүмүүс билүү бид чинь...

Төрийн маань хүч авлигадаа байна. Авлигаар төр хооллож, хоолныхоо төлбөрийг цатгалан тэнэгүүдэд эрх ямба болгон илгээнэ. Түшмэдүүд үндсэн ажлаа хийсний төлөө шан харамж нэхэж, эвэртэн туурайтнууд эрх мэдлээ хууль бусаар ашиглан садан төрөл, найз нөхөддөө албан тушаал бэлэглэж, жүнзэнд хоносон сархадын шавхруу мэт сулбагар төр засгийг бүтээцгээж байна. Тэдний чадах нь хүнд суртал. Лаг шаварт лавхан зоосон тагнаатай гадас мэт цул "хүнд сурталтнууд"-ыг төрийн хууль, түмний хэрэгцээ, яншаа хэрүүлчид, яарсан иргэд... хэн гуай нь ч хөдөлгөхгүй ч, ганц "амь оруулж" хөдөлгөн идэвхжүүлэгч ачтан нь зөвхөн АВЛИГА. Хөрсийг нүхлэж агааржуулдгийг нь бодоод талбайдаа оготно үржүүлээд байвал ямархан ургац авах билээ. Авлигын ачийг магтан дуулах нь түүн лугаа ижил. Авлигачидгүй, хүнд сурталгүй орчинд, хуулийн хамгаалалт дор дарамтгүй амьдрах боломж хайсан Монгол залуус "сүрэг сүргээрээ" харьд одоцгоож, "авлигын мөнгө шуудайлсан" хар элэгтнүүд гэр, төр хоёрт минь шургалахаар "вагон вагоноороо" зөрөн ирж улс мөхөөх аюулын харангыг дэлдэж эхэллээ.

Аяа, хүмүүс минь. Ташуураар жанчихаас нааш хөдөлдөггүй зовлонт адгуус хийгээд, хуулиар "жанчихаас" нааш сэхээрдэггүй "ухаант" хүмүүн хоёрт яг адилхан жанчих /Чингисийн монголчууд бидэнд ташуур хэрэгтэй/ жор л асар тустай. Авлига нь эдийн засгийн эрүүл хөрсний шим шүүсийг хог ургамал мэт сорон өсөлтийг сааруулж, нийгмийн ялгаа, тэгш бус байдлыг дэвэргэн хөөрөгдөж, хөгжил дэвшлийн тэнцвэрийг алагдуулан, нийгмийн эрүүл саруул сэтгэл зүйг бохирлон буртагладаг. Улмаар хүрээгээ тэлж үндэстний өрсөлдөх болон хөгжих чадварыг доройтуулан улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын дархлааг сулруулах аюултай үзэгдэл учраас **АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА** тэмцэхдээ бид мөр зэрэгцэн нэгэн зүгт уухайлан давшихдаа бус зүрх сэтгэл рүүгээ, оюун ухаан руугаа ухаарлын минь сэнтийг түрэмгийлэн эзэлсэн авлигын

чөтгөрийн үүр уурхай руу, ЧӨЛӨӨЛӨХ ДАЙН ЗАРЛАЖ ширүүн дайралт хийцгээе, Ард түмэн минь ээ! Авлигатай тэмцэхэд ХҮН БҮРИЙН ХҮЧИН ЗҮТГЭЛ хэрэгтэй.

Авлигагүй Монгол-бидний зүтгэлд, бидний итгэлд, бидний сэтгэлд . . .